

**НИЙСЛЭЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ  
2014 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН  
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛАН**

2014.09.17.

Улаанбаатар хот.

Тус албанд энэ оны гуравдугаар улиралд ирсэн 506 өргөдөл гомдлыг ангилвал 336 хүсэлт, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх 170 гомдол гаргасан. Өмнөх оны мөн үеийнхээс 55 өргөдөл гомдлоор ихэссэн үзүүлэлттэй байна.

**НЭГ. Нийт 170 гомдол ирсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 82 гомдлоор нэмэгдсэн байна.**

1.Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй удааширч байгаа талаарх төлбөр авагчийн 94 гомдол нь 55.3 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 48 гомдол буюу 3 хувиар өссөн.

2. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар төлбөр төлөгчийн 58 гомдол нь 34.1 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 39 гомдол буюу 12.5 хувиар өссөн.

3.Албадан дуудлага худалдааны талаарх 7 гомдол нь 5.3 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 2.6 хувиар буурсан.

4.Эд хөрөнгийн үнэлгээний талаарх 9 гомдол нь 5.3 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 5 гомдлоор нэмэгдэн, 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Ирсэн гомдлуудыг дүүрэг тус бүрээр харьцуулбал,

1. Баянгол дүүрэг	42 буюу	24.7 хувь
2. Сонгинохайрхан дүүрэг	19 буюу	11.2 хувь
3. Сүхбаатар дүүрэг	44 буюу	25.9 хувь
4. Баянзүрх дүүрэг	29 буюу	17 хувь
5. Чингэлтэй дүүрэг	21 буюу	12.4 хувь
6. Хан-Уул дүүрэг	13 буюу	7.7 хувь
7. Бусад	2 буюу	1.1 хувь

Өмнөх оны үлдэгдэл 18 гомдлыг нэгтгэн, шийдвэрлэвэл зохих 170 гомдлыг шийдвэрлэсэн байдлыг харвал:

-Гомдол гаргагчийн гомдлыг хүлээн авч, түүний дагуу шийдвэрлэсэн 44 буюу 24 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 32 буюу 10.4 хувиар өссөн.

-Гомдлыг хүлээн авах боломжгүй тухай хариу өгсөн 55 буюу 30 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 32 буюу 3.9 хувиар нэмэгдсэн.

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар танилцуулсан 84 буюу 46 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 34 гомдлоор нэмэгдсэн, 10.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**ХОЁР. Нийт 336 хүсэлт ирсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 27 хүсэлтээр бага байна.**

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашралттай байгаа талаарх төлбөр авагчийн 147 хүсэлт нь 43.8 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 15 хүсэлт буюу 0.8 хувиар буурсан.

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх төлбөр төлөгчийн 155 хүсэлт нь 46.1 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 23 хүсэлт буюу 2.9 хувиар багассан.

-Албадан дуудлага худалдааны талаарх 26 хүсэлт нь 7.7 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 10 хүсэлтээр их 3.3 хувиар буурсан

-Эд хөрөнгийн үнэлгээний талаар талаарх 8 хүсэлт буюу 2.4 хувийг буюу өмнөх оны мөн үеийнхээс 7 хүсэлт буюу 2.1 хувиар өссөн байна.

Хүсэлтийг дүүргүүдээр харьцуулан харуулбал:

1. Сүхбаатар дүүрэг	60 хүсэлт буюу 17.9 хувь
2. Баянзүрх дүүрэг	54 хүсэлт буюу 16.1 хувь
3. Баянгол дүүрэг	88 буюу хүсэлт 26.2 хувь
4. Чингэлтэй дүүрэг	63 буюу хүсэлт 18.8 хувь
5. Сонгинохайрхан дүүрэг	29 буюу хүсэлт 8.6 хувь
6. Хан Уул дүүрэг	37 хүсэлт буюу 11 хувь
7. ХӨТЯЭХэсэг	5 хүсэлт буюу 1.4 хувийг тус тус эзэлж байна.

Өмнөх оны үлдэгдэл 15 хүсэлтийг нэгтгэн, шийдвэрлэвэл зохих 351 хүсэлтийг шийдвэрлэсэн байдлыг харьцуулбал:

-Хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн 131 нь 38.2 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 48 буюу 15.3 хувиар нэмэгдсэн.

-Хүсэлтийг хүлээн авах боломжгүй хариу өгсөн 79 нь 23 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 23 хүсэлтээр бага 5.1 хувиар буурсан.

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар танилцуулсан 133 нь 38.8 хувийг буюу өмнөх оны мөн үеийнхээс 45 буюу 10.2 хувиар тус тус буурчээ.

Төлбөр төлөгчийн гаргасан өргөдөл гомдлыг харьцуулбал,

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа удаашралттай байгаа талаарх гомдол 58 гаргасан нь өмнөх оны мөн үеийнхээс 39 гомдлоор ихэссэн, хүсэлт 155 гаргасан нь өмнөх оны мөн үеийнхээс 23 хүсэлтээр буурсан үзүүлэлттэй байна.

Төлбөр авагчийн гаргасан өргөдөл гомдлыг харьцуулбал,

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдуулан 94 гомдол гаргасан нь өмнөх оны мөн үеийнхээс 48-иар их, 147 хүсэлт гаргасан нь өмнөх оны мөн үеийнхээс 15-р буурсан үзүүлэлттэй байна.

Албаны хэмжээнд төлбөр төлөгч 213, төлбөр авагч 241 өргөдөл гомдлыг тус тус гаргасан байна

Өмнөх оны үлдэгдэл 33 өргөдөл гомдлыг нэгтгэн, шийдвэрлэвэл зохих 538 өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдлыг харьцуулбал:

-Гомдол гаргагчийн гомдлыг хүлээн авч, түүний дагуу шийдвэрлэсэн 175 нь 33.3 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 13 буюу 12.3 хувиар нэмэгдсэн.

-Гомдлыг хүлээн авах боломжгүй тухай хариу өгсөн 134 нь 25.5 хувь буюу өмнөх оны мөн үеийнхээс 9 өргөдөл гомдлоор буурч, 2.3 хувиар ихэссэн.

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар танилцуулсан 217 нь 41.2 хувь өмнөх оны мөн үеийнхээс 14 буюу 10 хувиар буурсан байна.

Түүнчлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлэгч харьяа агентлагуудад хэрэгжүүлж байгаа өргөдөл гомдлын шинэчилсэн программ [www.smartcity.mn](http://www.smartcity.mn) хаягаар орж өргөдөл гомдлоо хэрхэн шийдвэрлэснээ хянах боломжийг бүрдүүлсэн бөгөөд 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2014 оны 09 дүгээр сарын 12-ны хооронд 506 өргөдөл бүртгэгдснийг төрлөөр ангилбал:

-1200 тусгай дугаарын утсаар гаргасан өргөдөл 5 буюу 0.99 хувь

-Засгийн газрын 11-11 төвд гаргасан өргөдөл 6 буюу 1.19 хувь

-ub1200.mn цахим хуудсаар 1 буюу 0.2 хувь

-Байгууллагад гаргасан өргөдөл 494 буюу 97.63 хувийг тус тус эзэлж байна.

Төрлөөр ангилан үзвэл:

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар 469 буюу 92.69 хувь

-Төлбөр төлөгчийн тухай 7 буюу 1.38 хувь

-Дуудлага худалдааны талаар 22 буюу 4.35 хувь

-НЗД-н хэрэгжүүлэгч агентлагуудын талаар 3 буюу 0.59 хувь

-Шүүх эрх мэдлийн байгууллагын төрийн албан хаагчийн талаар 4 буюу 0.79 хувь

-Цагдаагийн байгууллагын төрийн албан хаагчийн ёс зүйн талаар 1 буюу 0.2 хувь байна.


Нийт 494 өргөдлийг шийдвэрлэж, 12 өргөдөл гомдол шийдвэрлэх шатандаа байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 141 албан бичиг, Шийдвэр гүйцэтгэх газраас 107 албан бичгээр ирүүлсэн үүргийн дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, өргөдөл гаргагчид хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэжээ.


Тус албанд 70197019 дугаарын утсаар 6, цахим шуудангаар 22, амаар 135 өргөдөл гомдол гаргасны дагуу гүйцэтгэлийн хувийн хэргийг эрх бүхий ажилтан хянаж, хариуг өгсөн.

Албаны дарга, дэд дарга нар өргөдөл гомдлоор гүйцэтгэлийн хувийн хэргийг татан хянаж, мэргэжлийн удирдлагаар ханган, шийдвэр гүйцэтгэгч нарт давхардсан тоогоор нийт 177 албан даалгавраар үүрэг өгч, биелэлтийг эргэн хянасан. Хугацаанд өгсөн үүргийг хангалтгүй биелүүлсэн 2 шийдвэр гүйцэтгэгчийг дахин үүрэгжүүлж биелэлтийг шалгасан.


**2014 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРАЛД ИРСЭН НИЙТ ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ:**




**2014 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРАЛД ИРСЭН ГОМДЛЫГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ:**




2014 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРАЛД ИРСЭН ХҮСЭЛТИЙГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ:




2014 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРАЛД ИРСЭН НИЙТ ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ АНГИЛАН ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ:




2014 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРАЛД ИРСЭН ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ  
ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ



2014 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРАЛД ИРСЭН ХҮСЭЛТИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ  
ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ



## 2014 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРАЛД ИРСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ



Гарсан өргөдөл гомдлын дагуу гүйцэтгэлийн хувийн хэргийг татан хянаж шийдвэр гүйцэтгэгчийг үүрэгжүүлснээр, 3.524.606.9 мянган төгрөгийн үнийн дүнтэй 4 гүйцэтгэх баримт бичигт төлбөр төлөгчийн эд хөрөнгийг албадан дуудлага худалдаанд оруулж, 48.610.6 төгрөгийн үнийн дүнтэй 5 гүйцэтгэх баримт бичигт эд хөрөнгө битүүмжилж, 17 гүйцэтгэх баримт бичигт 30.735.6 мянган төгрөгийг хэсэгчлэн төлүүлж, 553.154.2 мянган төгрөгийн үнийн дүнтэй 18 гүйцэтгэх баримт бичгийг хааж дуусгавар болгосон байна.

Өргөдөл гомдолтой гүйцэтгэх баримт бичиг бүрт тогтмол хяналт тавьж, улирал бүр ШШГЕГазарт болон ШГГазарт шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх танилцуулгыг хүргүүлж байна.

-ШШГЕГазрын байнгын хяналтанд байдаг 42 гүйцэтгэх баримт бичгийг сар бүр, улирал бүр шалган ажилласнаар 22 гүйцэтгэх баримт бичгийн 372.515.7 мянган төгрөгийг хэсэгчлэн төлүүлж, 4.030.855.8 мянган төгрөгийн 13 гүйцэтгэх баримт бичгийг хааж дуусгавар болгосон.

-ШГГазрын хяналт байдаг 20 гүйцэтгэх баримт бичгийн 12 гүйцэтгэх баримт бичигт 23.685.5 мянган төгрөгийг хэсэгчлэн төлүүлж, 20.221.4 мянган төгрөгийн 4 гүйцэтгэх баримт бичгийг хааж дуусгавар болгосныг танилцуулсан байна.

Тус албанд гаргасан өргөдөл гомдлын тоо өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал нэмэгдсэнтэй холбоотойгоор шийдвэрлэлтийн тоо мөн өссөн үзүүлэлттэй. Гүйцэтгэх баримт бичиг хааж дуусгавар болгохын тул шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудын гаргасан хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж

байгаа нь төлбөр төлөлтийн бодит үзүүлэлт өсөхөд эерэгээр нөлөөлж байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулаагүйн улмаас өргөдөл гомдол гаргасны дараа явуулсан ажиллагааны талаар эргэн танилцуулдаг байсан нь өмнөх оны мөн үеийнхээс буурсан.

Төлбөр авагчаас шүүхийн шийдвэр биелэгдэхгүй удааширч байгаа тухай 30-40 хувь, энэ нь төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээд нь төлбөрийн чадваргүй, эд хөрөнгө орлогогүй, эрхэлсэн тодорхой ажилгүйтэй, түүнчлэн шийдвэр гүйцэтгэгч хуульд заасан хийгдвэл зохих хойшлуулшгүй ажиллагааг бүрэн явуулаагүйтэй холбоотой байгаа тул шийдвэр гүйцэтгэгчийн явуулж буй өдөр тутмын үйл ажиллагаанд тавих хяналт, дотоодын хяналт шалгалтыг сайжруулахад анхаарч, “Шийдвэр гүйцэтгэлийн бүртгэлийн систем”-г ашиглаж эхэлсэн нь бүртгэлээр тавих хяналтыг улам сайжруулсан.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудтай харьцах харьцаанд үл ойлголцох байдал үүссэн, төрийн албан хаагчийн ёс зүйн журмыг баримтлаагүй, хувь хүний онцлог, шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаарх ойлголт дутмаг, зөвхөн төлбөрийг авснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагддаг, бусад тохиолдолд явагдахгүй байна гэж үзэх хандлага их байгаагаас гомдол гаргаж байна. Төлбөрийн чадваргүй, хорих ял эдэлж байгаа, оршин суугаа газрын хаяг тодорхойгүйн улмаас төлбөр төлөгдөхгүй байгаа боловч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тасралтгүй явагдаж байгаа талаарх мэдээллийг төлбөр авагч нарт өгдөг механизмыг бий болгох нь төлбөр авагч нарын зүгээс гаргах гомдлыг багасгах боломжтой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, төлбөр авагч гомдол гаргасны дараа шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар тайлбарлах бус тэдэнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх зөв ойлголтыг өгснөөр төлбөр авагчийн зүгээс гаргах гомдлыг багасгах боломжтой гэж үзэн ажиллаж байгаа нь өргөдөл гомдлын шийдвэрлэлтээс харагдаж байна.

Өргөдөл гомдлыг шуурхай эцэслэн шийдвэрлэж, өргөдлийн тоог бууруулахын тул иргэдэд үзүүлэх үйлчилгээг нэн тэргүүнд тавьж, тэдэнд хэрэгтэй мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэж, уулзахыг хүссэн албан тушаалтантай нь уулзуулж асуудлыг газар дээр нь шийдэх боломжоор хангаж ажиллаж байгаагаас гадна шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж буй эсэх, уг ажиллагаанаас бусдын хууль ёсны эрх ашиг, сонирхол хөндөгдөж байгаад хяналт тавин ажиллаж байгааг танд танилцуулья.

ТАНИЛЦСАН:  
ДАРГА, ХУРАНДАА

Э.БАТБАЯР

ТАЙЛАН БИЧСЭН:  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,  
ДЭСЛЭГЧ

Ц.ЦОЛМОНТУЯА